

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/213/-НА-СТА-ТШЗ
ТӨВ АЙМГИЙН БАРУУН ЗУУНМОД БН ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/126
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАРУУН ЗУУНМОД
БНН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ 19020396

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,981,780.73	1,190,237,154.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	144,596.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	144,596.00
3121	Төгрөг	-	144,596.00
31211	Төрийн сангийн харилцах	-	23,785.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	120,811.00
33	АВЛАГА	14,491,553.00	240,544,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	240,544,100.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13,839,253.00	-
335	Бусад авлага	652,300.00	-
3351	Байгууллагаас авах авлага	652,300.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	23,490,227.73	949,548,458.38
351	Түүхий эд материал	21,454,977.73	930,694,690.58
35110	Тусгай зориулалттай материал	18,990,977.73	20,415,977.73
35130	Эм боох материал	2,464,000.00	910,278,712.85
354	Хангамжийн материал	2,035,250.00	18,853,767.80
35410	Бичиг хэргийн материал	37,200.00	1,452,500.00
35420	Аж ахуйн материал	599,000.00	9,247,106.00
35440	Түлш, шатах тослох материал	1,244,520.00	6,060,561.80
35450	Барилгын засварын материал	6,030.00	89,300.00
35460	Хүнсний материал	-	1,850,800.00
35470	Бусад хангамжийн материал	148,500.00	153,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	188,493,320.15	197,618,137.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	188,493,320.15	197,618,137.92
392	Биет хөрөнгө	183,780,643.48	193,203,961.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	165,575,524.00	165,575,524.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,302,431.85)	(40,905,549.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,067,432.00	28,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,215,755.43)	(6,030,038.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,778,635.00	135,408,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,784,356.61)	(90,248,234.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,787,465.00	22,685,965.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,125,868.63)	(22,161,840.00)
393	Биет бус хөрөнгө	4,712,676.67	4,414,176.67
39301	Програм хангамж	1,860,000.00	1,860,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(887,323.33)	(1,185,823.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,740,000.00	3,740,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	226,475,100.88	1,387,855,292.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,961,673.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,961,673.00
413	Өглөг	-	1,961,673.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,961,673.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	226,475,100.88	1,385,893,619.30
51	Засгийн газрын хувь оролцоо	226,475,100.88	1,385,893,619.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	255,441,591.45	255,441,591.45
51101	Өмч: - төрийн	255,441,591.45	255,441,591.45
512	Хуримтлагдсан үр дүн	(76,182,926.96)	1,083,235,591.46
51210	Өмнөх үеийн үр дүн	(112,590,786.46)	(76,182,926.96)
51220	Тайлант үеийн үр дүн	36,407,859.50	1,159,418,518.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,216,436.39	47,216,436.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	226,475,100.88	1,387,855,292.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	532,352,650.00	1,913,367,880.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	474,517,700.00	1,913,367,880.69
120	Нийтлэг татварын бус орлого	9,394,300.00	1,076,985,217.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,394,300.00	1,076,985,217.69
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,394,300.00	1,076,985,217.69
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	465,123,400.00	436,834,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	465,123,400.00	436,834,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,834,950.00	399,548,463.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,834,950.00	399,548,463.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,834,950.00	399,548,463.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	495,944,790.50	753,949,362.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,944,790.50	753,949,362.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,306,275.50	753,949,362.27
2104	Хангамж, бараа материалын зардал	20,302,780.00	29,298,599.20
210401	Бичиг хэрэг	6,221,910.00	6,748,650.00
210402	Тээвэр, шатахуун	5,501,840.00	3,907,083.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,579,030.00	18,642,866.00
2105	Нормативт зардал	58,000,014.00	294,731,241.84
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,307,014.00	290,505,191.84
210502	Хоол, хүнс	3,693,000.00	4,226,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,246,110.00	991,950.00
210604	Урсгал засвар	13,246,110.00	991,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,174,031.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,174,031.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	398,757,371.50	424,753,540.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	398,757,371.50	424,753,540.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,019,212.21	26,403,182.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,638,515.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,638,515.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,638,515.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,407,859.50	1,159,418,518.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	36,407,859.50	1,159,418,518.42

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	(112,590,786.46)	-	190,067,241.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	(112,590,786.46)	-	190,067,241.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	36,407,859.50	-	36,407,859.50
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	(76,182,926.96)	-	226,475,100.88
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	(76,182,926.96)	-	226,475,100.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(36,407,859.50)	-	(36,407,859.50)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	(112,590,786.46)	-	190,067,241.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	36,407,859.50	-	36,407,859.50
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,159,418,518.42	-	1,159,418,518.42
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.45	47,216,436.39	1,083,235,591.46	-	1,385,893,619.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	522,958,350.00	836,382,663.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	465,123,400.00	836,382,663.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	465,123,400.00	436,834,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	465,123,400.00	436,834,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,834,950.00	399,548,463.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,834,950.00	399,548,463.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,834,950.00	399,548,463.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	522,958,350.00	800,710,067.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,958,350.00	800,710,067.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503,480,582.00	800,710,067.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503,480,582.00	800,710,067.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	503,480,582.00	800,710,067.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,477,768.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,477,768.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,477,768.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	35,672,596.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	35,528,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	35,528,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	35,528,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	35,528,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(35,528,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	144,596.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	144,596.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	465,123,400.00	459,484,885.00	436,834,200.00	436,810,415.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,123,400.00	459,484,885.00	436,834,200.00	436,810,415.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,123,400.00	459,484,885.00	436,834,200.00	436,810,415.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	465,123,400.00	459,484,885.00	436,834,200.00	436,810,415.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	465,123,400.00	465,123,400.00	436,834,200.00	436,834,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,123,400.00	465,123,400.00	436,834,200.00	436,834,200.00
122005	Орон нутгийн төсвөөс	465,123,400.00	465,123,400.00	436,834,200.00	436,834,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	23,785.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00	24.00	24.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,995,697.00	399,427,652.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,995,697.00	399,427,652.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,995,697.00	399,427,652.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,995,697.00	399,427,652.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,995,697.00	399,427,652.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,834,950.00	399,548,463.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,834,950.00	399,548,463.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,834,950.00	399,548,463.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		120,811.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр, авлага, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх бүрд хүрч үйлчлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 4-ны өдрийн А/02 тушаалаар дотоод хяналтын журам баталж, дотоодын хяналтын баг жилд 2 удаа тооллого хийж хяналтын бүртгэл дээрх тоон дүнтэй харьцуулан шалгасан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд 2021 онд хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 532,352.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,985.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,589.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 28,700.5 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 20,715.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 532,352.7 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 1,913,367.9 мянган төгрөг, 1,381,015.2 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвд

мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 436,834.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,076,985.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 395,048.5 мянган төгрөг нийт 1,908,867.9 мянган төгрөг өмнөх оноос 1,376,515.2 мянган төгрөгөөр буюу 2.6 дахин нэмэгдсэн байна.

Зардал :

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 754,177.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 836,238.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 436,810.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140020601 тоот дансанд 2021 онд 490,784.2 мянган төгрөгийн орлого, 490,760.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 23.8 төгрөг байна. 100140020403 тоот дансанд 525,178.8 мянган төгрөгийн орлого, 525,058.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		144.6	-144.6
Авлага	14,491.6	240,544.1	-226,052.5
Урьдчилгаа			
Бараа материал	23,490.2	949,320.7	-925,830.5
Үндсэн хөрөнгө	188,493.3	197,618.1	-9,124.8
Нийт хөрөнгө	226,475.1	1,387,627.4	1,161,152.3
Өр төлбөр	0	1,961.7	-1,961.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	226,475.1	1,385,665.8	-1,159,190.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	226,475.1	1,387,627.4	1,161,152.3

Авлага дансны оны эхний үлдэгдэл 14,491.6 мянган төгрөгийг барагдуулж, оны эцсийн үлдэгдэл 240,544.1 мянган төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 цар тахлаар өвдсөн иргэдийн гэр эмчилгээний 10,11,12 дугаар сарын санхүүжилт дутуу өгснөөс авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 949,320.7 мянган төгрөг болж 925,830.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ковид-19 эмчилгээний

дархлаажуулалтын багц, вакцин, оношлуур зэрэг үнэ төлбөргүй авсан хөрөнгөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 197,618.1 мянган төгрөг болж 9,124.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь худалдан авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь худалдан авсан 35,528.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж акталж устгасан 6,187.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,385,665.8 мянган төгрөг болж 1,159,190.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 465,123.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 465,123.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 28,289.2 мянган төгрөгөөр бууруулан 436,834.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 436,834.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 436,834.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 436,834.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 436,810.2 мянган төгрөгийг зарцуулж, 23.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 436,810.2 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байгаа нь 23.8 мянган төгрөг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалаас нэг хүн эмчлэх

зориулагдсан зардал, 4 эмчилгээ үйлчилгээ, вакцины урамшууллаас 399,548.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бараа үйлчилгээний бусад зардалд 399,548.5 мянган төгрөгийг зарцуулж 120.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй гарсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв тайлант онд 34,629.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 898.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн газраас 1,076,985.2 мянган төгрөгийн ковид-19 цар тахлын вакцин, оношлуур үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв тайлант онд ковид-19 цар тахлаар өвдөж гэрээр тусгаарлагдсан 3131 хүнд 492,680.0 мянган төгрөгийн эм тариа зарцуулсан байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв тайлант онд ковид-19 цар тахлын үе өвдсөн хүмүүсийг гэрээр эмчилсэн эм тариа, вакцинжуулалтын зардалд 122,106.7 мянган төгрөг, ковид-19 цар тахлын вакцины урамшуулалд 52,658.4 мянган төгрөг, шатахуунд 8,307.8 мянган төгрөг, эмч ажиллагсдын урамшуулал, тэтгэмж, бичиг хэргийн зардалд 47,430.6 мянган төгрөг нийт 230,503.5 мянган төгрөг зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээлээгүй 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 25, зарлагын 29 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 12 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр, авлага, шилэн данс, худалдан авалттай холбоотой 3 зөвлөмж, өгөгдсөнийг хэрэгжүүлэн Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 6 дугаар сарын 4-ны өдрийн 39 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 291,184.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40,028.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 251,156.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.2.1 Залруулсан алдаа

1.Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд 35,528.0 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгө тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант оны Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 4,500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Өр,авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант оны эцсийн үлдэгдэл 240,544.1 мянган төгрөг нь Эрүүл мэндийн даатгалаас ковид-19 гэр эмчилгээний 10,11,12 дугаар сарын санхүүжилт дутуугаас авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

2.Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

1. Худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 10,611.9 мянган төгрөгийн 11 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	БЗӨЭМТ	3	291,184.0	2	40,028.0					2	251,156.0
Дүн		3	291,184.0	2	40,028.0					2	251,156.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн		3	291,184.0	2	40,028.0					2	251,156.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70272287
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn